


Ипотекийн зээлийн тайлан

2014 оны 6 дугаар сар

Банкууд 2014 оны 6 дугаар сард нийт 1858 зээлдэгчид 98.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 2440.0¹ тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 58793-т хүрчээ.

Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 3.5 нэгж хувиар буурсан ч, оны эхнээс 7.0 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 96.4 нэгж хувиар нэмэгдсэн байна.



Банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” (ОСИСТТБХ)-ийн хэрэгжилттэй холбоотойгоор 2013 оноос эхлэн эрс нэмэгдсэн байна.



*2014 оны 6-р сарын ипотекийн зээлийн үлдэгдлийг 2013 оны 12-р сарын нэрлэсэн ДНБ-д харьцуулсан.

Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 69.0 хувь буюу 1684.6 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 28.0 хувь буюу 683.2 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 3.0 хувь буюу 72.2 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.



¹ МИК-т шилжүүлсэн зээлийн дүн орсноор.

Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1858 иргэн шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 1202 иргэн “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 656 иргэн банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.




2014 оны 6 дугаар сарын байдлаар нийт 58793 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 38659 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 18032 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 2102 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 0.5-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 15.2 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2014 оны 6 дугаар сарын байдлаар 15.0 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 47.3 хувь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 38.8 хувь нь 16-20 жил, 38.5 хувь нь 11-15 жил, 18.8 хувь нь 6-10 жил, 3.9 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.



Зээлийн хүү

Банкуудын 2014 оны 6 дугаар сард олгосон ипотекийн зээлийн хамгийн өндөр хүү нь жилийн 26.4 хувь, хамгийн бага нь 2.4 хувь байсан бөгөөд тухай сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 10.5 хувь байв. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 6.1 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 16.1 хувь, валютаар олгосон зээлийнх 9.9 хувь байв.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

| Он | Сар | Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.) | Үүнээс: | Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар) | Тухайн сард олгосон зээлийн ЖДХҮҮ, жилээр (%) | Нийт зээлдэгч (тоогоор) | |
|------|-----|---------------------------------------|--------------------------|--|---|-------------------------|--------|
| | | | ОСИСТГБ хөтөлбөрийн зээл | | | | |
| 2008 | 12 | 217,977.5 | | 100.7 | 19.8 | 16,522 | |
| 2009 | 12 | 226,040.6 | | 103.4 | 18.7 | 16,784 | |
| 2010 | 12 | 333,776.6 | | 115.0 | 16.0 | 19,700 | |
| 2011 | 12 | 669,662.8 | | 154.3 | 14.8 | 26,869 | |
| 2012 | 12 | 845,204.4 | | 155.5 | 15.3 | 29,887 | |
| 2013 | 1 | 856,633.6 | | 149.1 | 17.0 | 29,683 | |
| | 2 | 873,666.4 | | 156.1 | 16.8 | 29,946 | |
| | 3 | 903,557.5 | | 158.6 | 15.7 | 30,419 | |
| | 4 | 944,516.8 | | 155.4 | 15.8 | 31,412 | |
| | 5 | 986,182.2 | | 147.8 | 16.6 | 32,247 | |
| | 6 | 1,032,156.7 | | 276,328.4 | 168.3 | 12.9 | 33,028 |
| | 7 | 1,273,003.6 | | 553,346.9 | 202.4 | 9.2 | 37,751 |
| | 8 | 1,461,753.4 | 781,483.2 | 207.6 | 8.9 | 40,596 | |
| | 9 | 1,611,383.8 | 943,976.7 | 206.0 | 9.1 | 42,968 | |
| | 10 | 1,750,781.6 | 1,076,924.5 | 193.9 | 9.6 | 45,138 | |
| | 11 | 1,834,042.7 | 1,155,409.2 | 192.8 | 9.7 | 46,482 | |
| | 12 | 1,938,945.3 | 1,248,633.8 | 192.8 | 9.9 | 48,320 | |
| 2014 | 1 | 2,021,424.9 | 1,324,898.9 | 194.4 | 9.8 | 49,731 | |
| | 2 | 2,121,802.6 | 1,382,084.1 | 193.2 | 9.9 | 53,611 | |
| | 3 | 2,193,368.6 | 1,451,938.1 | 190.7 | 9.9 | 54,787 | |
| | 4 | 2,280,503.5 | 1,538,506.8 | 192.1 | 9.8 | 56,137 | |
| | 5 | 2,365,349.5 | 1,618,127.2 | 189.3 | 10.0 | 57,579 | |
| | 6 | 2,440,007.1 | 1,684,583.9 | 182.3 | 10.5 | 58,793 | |